



НИЙСЛЭЛИЙН АЯЛАЛ ЖУУЛЧЛАЛЫН ГАЗРЫН
ДАРГЫН ТУШААЛ

2015 оны 07 сарын 27 өдөр

Дугаар 1173

Улаанбаатар хот


Хөрөнгө гаргах тухай

Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.4.5, “Найрсаг Улаанбаатар” хөтөлбөрийг 2015 онд хэрэгжүүлэх үйл ажиллагааны төлөвлөгөөний 2.4.9, нийслэлийн Аялал жуулчлалын газрын дүрмийн 2.3, 4.9 дэх заалтыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Нийслэл хотын аялал жуулчлалын бүтээгдэхүүн, үзмэрийг сурталчлах, “Найрсаг Улаанбаатар” хөтөлбөрийн хүрээнд хийгдэж буй арга хэмжээний талаарх мэдээллийг гадаад, дотоодод тогтмол хүргэх зорилгоор “Фрийдом студи”-тэй гэрээ байгуулан, хяналт тавьж ажиллахыг Мэргэжлийн сургалт хариуцсан мэргэжилтэн /Ш.Ундармаа/-д даалгасугай.

2. Гэрээт ажлын төсөв болох 9 800 000 /есөн сая найман зуун мянган/ төгрөгийг холбогдох зардлаас гаргахыг ахлах нягтлан бодогч /П.Ариунаа/-д зөвшөөрсүгэй.

ДАРГА



Э.БАТТУЛГА